

Татварын өршөөлийн хуулиудын хэрэгжилт, үр дүн: Монгол улсын жишээн дээр

Implementation and Result of Tax Amnesties: The Case of Mongolia

Б. Болор¹, Э. Ундармаа², Л. Хишигбаяр³

Хураангуй

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих зорилгоор хамгийн өргөн хэрэглэгддэг татварын бодлогын арга хэмжээ нь татварын өршөөл үзүүлэх явдал юм. Монгол Улсад 2007, 2008, 2015 онд татварын өршөөлийн хуулиудыг баталж хэрэгжүүлсэн байна. Манай орны хувьд татварын өршөөлийн хуулиуд нь илрээгүй байсан орлого, хөрөнгийг ил болгох, тэдгээрийг хууль ёсны бүртгэл хяналтад оруулах, татварын суурийг нэмэгдүүлэх болон татварын үндсэн зарчмуудыг хангах зэрэг зорилгыг хэрхэн биелүүлсэн, олон улсын туршлагатай харьцуулахад үр дүн нь ямар байгаа талаар судалж дүгнэхийг зорьсон болно. Судалгааны ажлын хүрээнд бизнесийн байгууллагуудын нягтлан бодогчид, татварын судлаач мэргэжилтнүүдээс асуулга, ярилцлагын аргаар судалгаа авч боловсруулалт хийсэн бөгөөд ТЕГ-аас гаргасан статистик мэдээллүүдийг ашиглав. Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар болон статистик мэдээллийн дүнгээс харахад манай улсад хэрэгжсэн уг хуулиуд нь үндсэн зорилгоо биелүүлээгүй, татварын үндсэн зарчмуудыг биелүүлж чадаагүй гэсэн үр дүн гарч байна.

Түлхүүр үгс: татварын өршөөл, татварын хуулийн хэрэгжилт, татварын өршөөлийн зэрэг сөрөг үр дагавар

Abstract

The tax system is the main approach to collect public budget revenues, and to accomplish economic policies. In accordance with taxation basic principles, tax must be fair, certain, convenient and efficient. A tax amnesty is the most efficient approach for realizing economic transparency. In 2007, 2008, 2015, tax amnesties implemented in Mongolia. The purpose of this paper is to study and conclude endeavor of tax amnesties such as detection and validation of skim money and asset, increasing tax base, elimination of falsification and to compare the performance with international practice. Our research data that is taken survey from business entity's accountants, experts and researchers of taxation besides statistic data is taken from Mongolian tax administration. Result of the survey that tax amnesties are implemented in Mongolia isn't compliance with taxation basic principles and isn't reach main purpose. Thus, police makers have to do amnesty program that is consider about how to implement tax amnesties to entities that didn't involve amnesty before and do research about result of prior amnesties.

Keywords: tax amnesty, tax compliance, benefit and cost of tax amnesty

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш
E-mail: bolor_buren@yahoo.com

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш
E-mail: undarmaa.enhee@yahoo.com

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн багш
E-mail: khishgee_8888@yahoo.com

1. Татварын өршөөлийн үндсэн ойлголт

Татварын өршөөл нь эртнээс үүсэлтэй, олон улс орнуудад өргөн хэрэглэгддэг, оновчтой зохион байгуулж чадсан тохиолдолд эерэг үр дүн үзүүлдэг арга хэмжээ юм. Татварын өршөөлийн талаарх хамгийн эртний мэдээлэл МЭӨ 200-аад оны үед хамрагдах бөгөөд Египетийн Розеттагийн чулууны бичээс дээр Мемпис сүмийн сүсэгтнүүд их хэмжээний татварын өрийг ард иргэдээр төлүүлэхгүй байх шийдвэр гаргасанд нь хаандаа талархаж байгаа тухай бичсэн байдаг байна.

Өршөөл гэдэг нь гэм бурууг хэрэгсэхгүй болгоно гэсэн үг бөгөөд татварын өршөөлийг зарлахдаа төлөгдөөгүй татвар, алданги, торгуулийн дүнгийн чухам алийг нь уг өршөөлийн хөтөлбөрт хамруулахаа тодорхой заадаг байна. Татварын өршөөл нь ихэнхдээ улс төрийн дэглэмийн өөрчлөлт, үндэсний мөнгөн тэмдэгтийн өөрчлөлт, эдийн засгийн хямралын дараа дагалдан хэрэгжүүлдэг татварын болон бусад холбогдох салбарын том шинэчлэлийн эхний үе шат байдаг. Татварын өршөөлийг эдийн засгийн тодорхой нөхцөлд, тодорхой хөтөлбөр, хугацаатайгаар авч хэрэгжүүлнэ. Татварын өршөөл хэрэгжүүлснээр улс орны эдийн засгийн байдал болоод татварын орлого, татвар төлөгчдөд богино болон урт хугацааны нөлөөлөл үзүүлдэг. Энэхүү нөлөөлөл эерэг, сөрөг байх нь өршөөлийн хөтөлбөрийн дараа хууль тогтоогчдын хэрэгжүүлэх татварын бодлогоос шууд хамаарна. Хууль тогтоогчид болон засгийн газрууд татварын өршөөлийн шинэ төрөл хэлбэрийг байнга боловсруулан гаргаж байдаг. Татварын өршөөлийг дахин давтан хэрэгжүүлэх нь өмнө зарласан өршөөлд хамрагдаагүй үлдсэн бүлэгт боломж олгох зорилготой. Өршөөлийн

хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, давтамж, хугацааг сунгах эсэх, өршөөлд хамрагдах татварын төрөл зэргээс үр дүн шууд хамаардаг. Татварын өршөөлд хамрагдаж, нуусан хөрөнгө, орлогоо мэдүүлсэн татвар төлөгчийн хувьд хууль хэрэгжиж дууссаны дараа татварын албаны хяналтад орох тохиолдол байна. Хэрэв Засгийн газар татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын өршөөлд хамрагдахыг дэмжих сонирхолтой байгаа бол татварын өршөөлд хамрагдагсдын нэрийг нууцлах болон татварын хяналт шалгалтыг хязгаарлах, хийхгүй байх зэргийг санал болгож болно.

Хамрах хүрээ

Татварын өршөөлийг хэрэгжүүлэхдээ тухайн өршөөлд ямар төрлийн татвар төлөгч хамрагдаж болохыг ялгаж тодорхойлох шаардлагатай. Ихэнхдээ татварын өрөө төлөөгүй татвар төлөгчдийг татварын өршөөлд хамруулдаг ба тэдгээр нь татварын албанд бүртгэлтэй, мөн бүртгэлгүй ч байж болно. Татварын шалгалтаар зөрчил илэрсэн татвар төлөгчдийг татварын өршөөлд хамруулах журам нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал: зөвхөн мэдэгдэж буй өр төлбөрийг, зарим тохиолдолд бүх тайлагнаагүй өр төлбөрийг хамруулдаг. Татварын өршөөлд байнгын болон түр оршин суугчид, мөн тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд хамрагдаж болно. Татварын өршөөлд ямар татвар төлөгчдийг хамруулах вэ? гэдгийг шийдвэрлэх нь төсөвт төвлөрүүлэх орлогыг тооцоолоход нөлөөлөх чухал хүчин зүйлсийн нэг юм.

Татварын өртэй нь тодорхой байгууллагуудаас өршөөлд хамруулахгүйгээр ч татвараа хурааж авах боломжтой байдаг тул татварын албанд мэдэгдэж буй

авлагын дүнгээс илүү орж ирсэн орлогыг татварын өршөөл хэрэгжүүлсний дүнд орсон орлого гэж үздэг. Мөн татварын өршөөлд ямар төрлийн татваруудыг хамруулахаа шийдвэрлэх ёстой бөгөөд ихэнхдээ хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар эсвэл хөрөнгийн албан татвар зэрэг зөвхөн нэг нэр төрлийн татварыг хамруулдаг. Хууль бусаар гадагшаа гарсан хөрөнгө (оффшор)-ийг буцааж татахын тулд хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийн төлөх ёстой бүх төрлийн татварыг татварын өршөөлд хамруулж болно. Өршөөлд хамрагдах татварын нэр төрлийг тодорхойлсноор татварын өршөөлд хамрагдах эрх бүхий этгээдийг хязгаарладаг байна.

Зарим улс оронд татварын хяналт шалгалтаас өмнө татвараас зайлсхийсэн гэдгээ сайн дураараа тайлагнасан татвар төлөгч нь татварын өршөөлд хамрагдаж болдог ба зөрчил гарснаас хойш тодорхой хугацаанд л өршөөгдөх боломжтой байдаг.

Татварын өршөөлийг хэрэгжүүлэх зарим хэлбэрүүд

Ихэнх татварын өршөөл нь иргэний болон эрүүгийн хариуцлагын хүрээн дэх торгуулийн хэмжээг бууруулах буюу бүрэн чөлөөлдөг бөгөөд татварын үндсэн дүнг нөхөн төлүүлдэг. Гэхдээ зарим тохиолдолд татварын хувь хэмжээг хуульд заасан хувь хэмжээнээс бууруулан төлөхийг зөвшөөрдөг. Тухайлбал, Энэтхэгт хэрэгжсэн татварын өршөөлийн хуулиар 1997 оны 7-р сараас эхлэн өмнө нь 97.75 хувь хүртэл байсан хувь хүний орлогын албан татварыг 30 хувиар тооцоолж төлөх боломжийг олгожээ. Татварын төлбөрт ногдох алдангийн хэмжээг өршөөлд хэрхэн хамруулах нь харилцан адилгүй

байдаг. АНУ-ын ихэнх мужид өршөөлийн хүрээнд мэдүүлсэн татварын төлбөрт ногдох алдангийг чөлөөлдөггүй, харин зарим мужид уг алдангийг хэсэгчлэн эсвэл бүрэн чөлөөлдөг байна. Бусад улсын хувьд дээрх хоёр хандлагын аль алийг хэрэглэнэ. Мөн татварын өршөөлд хамрагдагсдыг татвараа хэсэгчлэн төлөхийг зөвшөөрч болох бөгөөд энэ үед алдангийг хэрхэн төлөхийг татварын алба шийдвэрлэдэг туршлага байдаг. Мөн ил болгосон татварын төлбөрийг банкинд байршуулахыг зөвшөөрч тухайн банкны хадгаламжийн сертификатыг ирээдүйн татварын шалгалтын хамгаалалт⁴ болгодог байна. Тухайлбал, Италид 2001 онд “scudo fiscal” буюу татварын хамгаалалтын энэхүү аргыг хэрэгжүүлсний дараа 2011 онд татварын шинэ хууль баталсан байна. Энэ хуулинд татварын алба татвар төлөгчдийн дансанд хяналт тавих эрхтэй бөгөөд тусгай эрхийн дагуу олж авсан мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй гэж заажээ. Татварын өршөөлд янз бүрийн хөшүүрэг ашиглаж болдог. Тухайлбал, өршөөлд хамрагдагсад нь нуусан татварын хэмжээгээр Засгийн газрын тусгай нөхцөлтэй бонд худалдан авах шаардлагатай бөгөөд уг үнэт цаас нь хүүгүй эсвэл маш бага хүүтэй, хугацаа нь дуусахаас өмнө арилжих эрхгүй байдаг. Ийм төрлийн татварын өршөөл нь 1991 онд Испани улсад хэрэгжсэн байна. Өөрөөр бас нуусан татварыг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр хувийн компанид хөрөнгө оруулалт хийлгэдэг татварын өршөөл 1987 онд Аргентинд хэрэгжсэн байна.

Үргэлжлэх хугацаа, давтамж

Татварын өршөөлийг хэрэгжүүлж байгаа хугацаа, давтамжаар нь дараах байдлаар

⁴ tax shield

3 ангилж болно. Үүнд:

1. *Нэг удаагийн богино хугацааны өршөөл*: Энэ нь ихэвчлэн нэг удаа, хоёр сараас нэг жил хүртэл үргэлжлэх хугацаатайгаар хэрэгжинэ. Нэг удаагийн богино хугацаатай өршөөл нь татвар төлөгчдөд хараахан төлж амжаагүй байгаа татвараа төлж барагдуулах цорын ганц боломж олгодог.
2. *Дахин давтан хэрэгжих өршөөл*: Зарим оронд татварын өршөөлийг тухай бүр нь нэг удаагийнх хэмээн зарлаж, дахин давтан хэрэгжүүлэх явдал байдаг⁵.
3. *Байнгын өршөөл*: Ийм төрлийн өршөөлийн үед өнгөрсөн хугацааны орлогод ногдох татварыг хэвийн хувь хэмжээгээр нөхөн төлөх боломжийг олгодог ба заагдсан хугацаанд багтаан сайн дураараа татвараа нөхөн төлж байгаа этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг⁶.

Татварын өршөөлийн үр дүн

Татварын өршөөлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үеийн эдийн засгийн болон бусад нөхцөлүүд, хэрэгжүүлэх арга зам, хамрах хүрээ, давтамж, хугацаа, өршөөлд хамрагдагсдад үзүүлэх хөнгөлөлтийн нөхцөлүүд, өршөөлийн дараа татварын системд орох өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан уг хөтөлбөрийн үр дагавар нь янз бүр байдаг. Иймд Засгийн газрууд уг үр дагавруудыг нарийн тооцоолсны үндсэн дээр татварын өршөөлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Татварын өршөөлийн эерэг үр дагавар:

1. Богино хугацаанд татварын орлого болон ДНБ-ийг нэмэгдүүлдэг.

2. Татвар хураалтын зардлыг бууруулдаг.
3. Далд эдийн засгийг ил болгодог.
4. Татварын өршөөл үзүүлсний дараа татварын хуулийг биелүүлэх явдал сайжирдаг:
 - Өмнө нь татварын албанд бүртгэлгүй байсан этгээдүүд бүртгүүлж, татварын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж эхэлнэ.
 - Татварын өршөөл нь татварын системийн шинэчлэлийн эхний алхам байдаг бөгөөд өршөөлийн дараа татварын албадлага, торгууль чангарч, татвар төлөгчдийн боловсрол, тэдэнд үзүүлж байгаа татварын үйлчилгээ нэмэгддэг.
5. Хөрөнгө, орлогоо нуусан аж ахуйн нэгжийн хувьд өршөөлд хамрагдсанаар хөрөнгийн биржид бүртгэлтэй болж, өрийн болон өмчийн үнэт цаас гаргах боломжтой болдог.
6. Татвар төлөгчийн нуусан хөрөнгө, орлого нь ирээдүйн татварын шалгалтаар илрэхтэй холбоотой айдсыг бууруулдаг.
7. Ирээдүйд үүсэх өр төлбөрийг бууруулдаг. Тухайлбал, татварын зарим өршөөлийн үед хэд хэдэн жилийн туршид тайлагнасан орлого нь тодорхой хувиар байнга нэмэгдэж ирсэн татвар төлөгчийг татварын шалгалтад хамруулдаггүй байна⁷.

Татварын өршөөлийн сөрөг үр дагавар:

1. Татвараа үнэнчээр төлж байсан татвар төлөгчдөд татварын өршөөл шударга бус санагдсанаас татвараа шударгаар тайлагнаж төлөх сонирхол буурна.
2. Засгийн газар татварын хуулийг

⁵ 1970-аад оноос хойш Аргентин, Энэтхэг, Итали, Франц, Бельги, Филиппин, ОХУ зэрэг улсад хэд хэдэн удаагийн татварын өршөөлийг хэрэгжүүлсэн байна.

⁶ АНУ, Канад, Герман, Нидерланд, Норвеги, Швед зэрэг улс татварын байнгын өршөөлийг хэрэгжүүлдэг.

⁷ Португали улс энэ төрлийн өршөөлийг 1986 онд хэрэгжүүлсэн.

хэрэгжүүлэх, албадлага хэрэглэх хүч дутмаг гэдгийг зарим татвар төлөгчид ойлгосон үед татварын хуулийн хэрэгжилт буурдаг.

3. Татвараа төлөхгүй ч байсан өршөөгдөж болдог гэж ойлгосон татвар төлөгчийн хувьд хүлээлт үүсдэг.
4. Шударга бус татвар төлөгчдөд давуу тал бий болдог.
5. Урьдчилан тооцоолсноос бага орлого цуглуулах, татварын орлого буурах тохиолдол байдаг.
6. Татвар хураалтын болон хяналт шалгалтын зардал буурахгүй байх зэрэг болно.

2. Судлагдсан байдал

Татварын өршөөлийн төрөл, хэлбэр, хэрэгжилт, үр дүнгийн талаар судлаачид олон талаас нь судалгаа хийж, өөрсдийн дүгнэлт, саналыг боловсруулсан байдаг. Тухайлбал:

Stella (1989) татварын өршөөлийг татварын албадлагыг чангаруулах шийдвэр гаргахын өмнө хэрэгжүүлбэл зохистой хэмээн үзсэн байна.

Alm нар (1998) татварын өршөөлийн төрөл, хамрах хүрээ, эерэг сөрөг үр дагавруудыг олон улсын жишээн дээр судалж, татварын өршөөлийг татварын системийн өөрчлөлттэй хавсарч хэрэгжүүлсэн үед хамгийн сайн үр дүн үзүүлж байна хэмээн дүгнэжээ.

Torgler нар (2005) Alm нар (1998)-ын томъёолсон загвараар Коста Рика улсын 54, Швейцари улсын 68, нийт 122 татвар төлөгчийг хамруулсан судалгаа хийжээ. Уг судалгааны ажлын хүрээнд татварын хуулийн хэрэгжилт ба татвар төлөгчийн өршөөлд хамрагдах эсэхээ өөрөө шийдэх боломжийн хоорондын хамаарлыг

судалсан байна. Судалгааны үр дүнд татварын өршөөлийг давтан хэрэгжүүлэх нь татварын хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлдэггүй бөгөөд татвар төлөгчид өршөөлд хамрагдах эсэхээ өөрсдөө шийдэх боломжтой байх нь цаашид татварын хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж болох юм хэмээн дүгнэжээ.

Luitel нар (2007) АНУ-ын мужуудад 23 жилийн хугацаанд хэрэгжсэн 76 удаагийн өршөөлийн хөтөлбөрүүдийг хамруулан судалж, татварын өршөөлийн дүнд богино хугацаанд орлого нэмэгддэг боловч цаашлаад татварын хуулийн хэрэгжилт, үнэнч татвар төлөгчид буурах хандлагатай байдаг тул урт хугацаанд засахад төвөгтэй санхүүгийн асуудал үүсгэдэг хэмээн тодорхойлжээ.

Ваег нар (2008) “Татварын өршөөлийг эдийн засгийн бууралт, санхүүгийн хямралтай нөхцөлд хэрэгжүүлэх нь тохиромжтой. Татварын өршөөлийг бодлого тодорхойлогчид богино болон дунд хугацааны орлогыг нэмэгдүүлэх үр ашигт хэрэгсэл болгон ашиглаж ирсэн бөгөөд богино хугацаанд орлого нэмэгддэг ч тооцоолж байсан хэмжээнд хүрдэггүй. Харин дунд хугацаанд татварын суурь өргөжиж үүний үр дүнд ирээдүйн татварын орлого нэмэгдэх, мөн татвараас зайлсхийгчдийг бүртгэлд хамруулдаг. Өөрөөр хэлбэл, татвар төлөх үүргээ биелүүлэх эерэг хандлагыг төлөвшүүлдэг” гэж дүгнэжээ.

Feld нар (2010) үнэнч татвар төлөгчид татварын өршөөлийг татвараас зайлсхийгчдийн хувьд шагнал, өөрсдийнхөө хувьд шийтгэл мэтээр хүлээн авдаг бөгөөд энэ нь татварын хуулийн хэрэгжилтийг бууруулах нөлөөлөл үзүүлдэг гэж дурджээ.

Кага (2014) Туркийн Дундад Дорнодын техникийн их сургуульд мастерийн зэрэг горилох судалгааны ажилдаа Турк улсад 1961-2011 оны хооронд хэрэгжсэн 23 удаагийн татварын өршөөлийн далд эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг судалжээ. Татварын өршөөл бүрийн дараа далд эдийн засагт үзүүлж байгаа нөлөөлөл нь харилцан адилгүй байсан байна.

Mouloud (2015) хөгжингүй болон хөгжиж буй орнуудын бодлого тодорхойлогчид нь далд эдийн засгийг ил болгохдоо татварын өршөөлийг гол хөшүүрэг болгон ашигладаг гэж авч үзсэн байна. Татварын өршөөлийн хөтөлбөр амжилттай болох эсэх нь татварын албаны бүтээмжийг нэмэгдүүлэх, өршөөлийн хөтөлбөрт хамрагдах ач холбогдлыг ойлгуулах, татварын системийн шинэчлэлийг оновчтой хийх гэсэн гурван үндсэн хүчин зүйлээс хамаарна гэж үзжээ.

3. Судалгааны хэсэг

3.1. Бусад улс оронд татварын өршөөлийн хуулийг хэрэгжүүлсэн байдал

Улс орнуудын Засгийн газар болон орон нутгийн захиргаа аль аль нь татварын өршөөлийг хэрэгжүүлдэг. Сүүлийн 50 жилийн хугацаанд хөгжингүй орнуудын Засгийн газрууд эдийн засгийн уналт, хямрал, их хэмжээний гадаад өр, зээл зэрэг тодорхой эдийн засгийн асуудлуудаас үүссэн хохирлоос шалтгаалан; мөн Аргентин, Колумб, Турк зэрэг зарим хөгжиж буй орны Засгийн газар татварын өршөөлийг дахин давтан хэрэгжүүлсэн байна. Дээрх улс орноос гадна хөгжингүй, хөгжиж буй орнуудын Засгийн газар гадаад худалдааг нээлттэй болгох, эдийн засгийн ардчиллыг хөгжүүлэх эсвэл гадагш гарсан баялгийг эх орондоо эргүүлэн татах зэрэг

зорилгоор татварын өршөөлийн зарим хэлбэрийг хэрэглэсээр байна.

Аргентин: Аргентин улс 1987 онд гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг эргүүлэн татах зорилгоор татварын өршөөлийг хэрэгжүүлжээ. Уг өршөөлийн хүрээнд гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтаас олсон орлогыг татвараас чөлөөлсөн байна. Хөрөнгө оруулагч нь татвараас чөлөөлөгдсөн хэмжээтэй адил дүнгээр сан байгуулж, уг сангаа шинэ тоног төхөөрөмж худалдан авах, шинэ барилга байгууламж барих, хуучин хүчин чадлыг сайжруулахад зарцуулсан байхыг шаардсан ажээ. Засгийн газар нь уг санд төвлөрүүлсэн хөрөнгөөс ямар нэгэн татваравахгүй бөгөөд өршөөлд хамрагдсан татвар төлөгчдийг мөрдөж шалгаж яллахгүй хэмээн амлалт өгсөн байна. Хамгийн чухал нь Аргентин улсад олон удаагийн татварын өршөөл хэрэгжиж байсан боловч 1987 оны өршөөл нь санхүүгийн системд ямар ч өөрчлөлт оруулаагүй бөгөөд татварын албадлагын арга хэмжээг дээшлүүлсэн ямар нэгэн үр дүнд хүрээгүй юм. Аргентиний туршлагаас харахад бүтцийн ямар нэгэн өөрчлөлттэй хавсраагүй татварын өршөөл нь амжилтгүй болдог гэсэн сургамж авч болно.

Энэтхэг: Аргентинтай адилаар Энэтхэг олон удаагийн татварын өршөөл үзүүлсэн түүхтэй бөгөөд тэдний ихэнх нь татварын орлогыг бууруулсан буюу маш бага орлого оруулсан байна. Харин 1997 онд хэрэгжүүлсэн татварын өршөөл өөр байсан бөгөөд нийт 350 мянга гаруй хувь хүнээс 2.5 тэрбум долларын татварын орлого цуглуулсан нь өмнөх бүх өршөөлийн үр дүнд цугласан орлогоос даруй 3 дахин их байв. Хувь хүний орлогын татвар Энэтхэгийн ДНБ-ий 2%-иас ч бага байдаг боловч энэ орлого нь

орлогын албан татвараас ордог орлогоос 1.5 дахин их байсан байна. Дээрх орлогын ихэнх хэсгийг өршөөлийн сүүлийн өдрүүдэд цуглуулсан байна. Зөвхөн Делид гэхэд татварын өршөөлийн сүүлийн өдөр 12 мянга орчим хүн татварын өршөөлд хамрагджээ. Энэтхэгийн татварын өршөөл 1997 оны 7-р сараас 12-р сарыг дуустал 214 хоног үргэлжилсэн бөгөөд татвар төлөгчид өмнө нь тайлагнаагүй орлогоо тайлагнаж, ногдох татвараа тухайн үед мөрдөгдөж байгаа татварын хувиар тооцож төлөх боломжтой байсан аж. Тухайн үеийн татварын хувь хэмжээ 30% байсан бол өмнөх үеийн татварын хувь хэмжээ дээд тал нь 97.75% хүрч байжээ. Энэ өршөөл нь хувь хүмүүсийн өмнөх жилүүдэд худалдан авсан татвар ногдох хөрөнгийг инфляци өндөр байх үед тухайн үеийн ханшаар бус, худалдан авсан үеийн ханшаар мэдүүлэхийг зөвшөөрсөн байдаг. Уг өршөөлийн хуулийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр урлаг спортын оддыг ашиглан өргөн сурталчилгаа хийсэн байна. Сангийн сайд нь энэ өршөөл нь сүүлийнх гэдгийг дахин дахин мэдээлж байлаа. Эцэст нь хэлэхэд Энэтхэгийн энэ өршөөлийн хууль нь маш амжилттай хэрэгжсэн юм.

Ирланд: 1988 оны 1-р сард Ирландын Засгийн газар татвар төлөгчдөд 10 сарын турш хугацаа хэтэрсэн татварын өрөө ямар нэгэн хүү торгууль, иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлгүйгээр төлөх боломж олгожээ. Үүний зэрэгцээ Засгийн газар татварын байцаагчдын тоог нэмсэн бөгөөд татвараас зайлсхийсэн этгээдүүдийн нэрийг үндэсний өдөр тутмын хэвлэлд нийтэлж эхэлсэн байна. Засгийн газраас татварын өршөөл үзүүлсний дараа татварын алданги,

торгууль; татварын байцаагчдын хөрөнгө хураах, битүүмжлэх эрхийг нэмэгдүүлсэн заалт бүхий татварын шинэ системийн талаар танилцуулжээ. Засгийн газрын тооцоолсноор 50 тэрбум долларын татварын орлого орж ирэх ёстой байсан боловч үнэн хэрэгтээ 750 тэрбум долларын орлого цуглуулсан байна. Энэхүү үр дүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн аж. Үүнд:

- Өмнө нь Ирландад татварын өршөөл хэрэгжиж байгаагүй бөгөөд ЗГ энэ өршөөлийг эхний бөгөөд эцсийнх хэмээн танилцуулсан,
- Татварын өршөөлийн дараа нэмэгдэж байгаа татварын албадлагын арга хэмжээнүүд өмнөхөөс эрс өөрчлөгдсөн нь уг өршөөлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хүчтэй нөлөөлсөн зэрэг болно.

Колумб: 1987 онд Колумбын татварын өршөөл нь хувь хүмүүсийг өмнө нь тайлагнаагүй хөрөнгө болон буруу тайлагнасан татварын өрөө ямар нэгэн торгууль шийтгэлгүйгээр залруулах боломж олгосон байна. Хувь хүмүүс дор хаяж өнгөрсөн жилийнхээс багагүй орлого тайлагнах ёстой бөгөөд татвараас зайлсхийсэн нь илэрсэн этгээдүүдийг өршөөлд хамрагдахыг зөвшөөрсөн болно. Колумбын Засгийн газар татварын системдээ олон өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, орлогын татварын хувийг бууруулсан, ногдол ашгийн давхар татварыг байхгүй болгосон, гадаадын хөрөнгө оруулагчийн ашгийн татварын⁸ хувь хэмжээг нэмэгдүүлсэн гэх мэт. Үүний зэрэгцээ Засгийн газрын зүгээс албадлагын арга хэмжээ, торгуулийг нэмэгдүүлжээ. Энэхүү өршөөлийн хүрээнд 100 сая орчим долларын орлого буюу 1987 оны ДНБ-ний 0.3%-тай тэнцүү орлого

⁸ withholding tax

цуглуулсан байна.

Франц: 1986 онд Франц улсад татварын өршөөлийг гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг эргүүлэн татах зорилготойгоор хэрэгжүүлсэн байна. Засгийн газар өршөөлийн хуульд хамрагдан буцаан татсан хөрөнгөнд ногдох татварыг чөлөөлж, өршөөлийн дараа уг хөрөнгөнд ногдуулах татварын хувь хэмжээг бууруулсан аж. Энэхүү өршөөл нь 1982 онд хэрэгжүүлсэн өршөөлтэй ижил хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд өршөөлийн хөтөлбөрийг татварын албадлагыг нэмэгдүүлэх буюу торгуулийн хэмжээг өсгөх зэрэг арга хэмжээтэй хавсруулаагүйн улмаас маш бага хэмжээний орлого олсон хэмээн судлаачид таамаглажээ.

АНУ, Колорадо муж: АНУ-ын Колорадо мужийн татварын өршөөл нь АНУ-ын бусад мужуудад хэрэгждэг татварын өршөөлтэй ижил төстэй байдлаар хэрэгжсэн байна. Энэ өршөөл нь хувь хүмүүс болон бизнесийн байгууллагуудад татварын өрөө ямар нэгэн торгууль, эрүүгийн хариуцлага хүлээхгүйгээр төлөх нэг удаагийн боломж олгожээ. 1985 оны 6-р сарын 6-нд хуульчлагдсан энэхүү өршөөл нь 9-р сарын 15-наас 11-р сарын 15-ныг хүртэл 2 сарын хугацаанд хэрэгжсэн байна. Татварын өршөөл нь хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хэрэглээний болон онцгой албан татваруудыг хамруулжээ. Хувь хүний орлогын албан татварын өршөөлөөс орсон орлого нь нийт өршөөлийн орлогын 90%-ийг эзэлсэн байна. Өршөөлийг хэрэгжүүлэхдээ 5 сая долларын орлого олохоор тооцоолсон боловч 6.3 сая долларын орлого олжээ.

Индонез: Хамгийн сүүлийн байдлаар Индонезийн засгийн газар 2016, 2017 онд 2

үе шаттай татварын өршөөлийг үзүүлжээ. Уг өршөөлийн эхний үе шат нь 2016 оны 10 сараас 12 сар хүртэл үргэлжилж, 7 тэрбум долларын хөрөнгө, орлогыг ил болгосон байна. Хоёрдахь үе шат нь 2017 оны 1 сараас 3 сар хүртэлх хугацааг хамарч, одоогийн байдлаар 5.5 тэрбум долларын хөрөнгө, орлогыг ил болгоод байна. Энэ нь урьдчилан тооцоолсон хэмжээнээс хавьгүй их байна. Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд Сангийн сайд Sri Mulyani нь олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан, ерөнхийлөгч Joko Widodo өөрөө өршөөлийн хуульд хамрагдаж, нуусан хөрөнгө орлогоо ил болгон үлгэрлэсэн, татвар төлөхөөс зайлсхийсэн хуулийн этгээдийг хэвлэл мэдээлийн хэрэгслээр мэдээлсэн гэх мэт үйл ажиллагаанууд нь ихээхэн хөшүүрэг болжээ. Энэхүү өршөөлийг хэрэгжүүлснээр татварын бааз суурийг 20,000 шинэ татвар төлөгчөөр өргөжүүлжээ.

Зарим улс орны татварын өршөөл хэрэгжүүлсэн хэлбэр болон үр дүнг товч нэгтгэн Хүснэгт 1-д харууллаа.

3.2. Монгол Улсад татварын өршөөлийг хэрэгжүүлсэн байдал

Манай улсын татвар нь албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэх бөгөөд 1990-ээд оноос хойш УИХ-аар батлагдсан татварын хуулиудын дагуу хөрөнгө, орлого, хэрэглээнд ногдуулсан татвараа сайн дурын үндсэн дээр өөрөө тодорхойлон төлж, тайлагнах тогтолцоо хэрэгжиж байна. Мөн 2007-2015 он хүртэл улсын татварын орлого, татвар төлөгчдийн тоо тодорхой хувиар өсч байсан ба татварын бодлого, удирдлага нь татварын бааз суурь, татвар төлөгчдийг нэмэгдүүлэх, тэдгээрийг дэмжих, урамшуулах, бүртгэл

Хүснэгт 1. Зарим улс орнуудад татварын өршөөл хэрэгжүүлсэн байдал

№	Улс	Өршөөл хэрэгжүүлсэн он	Өршөөлд хамрагдагсад ба татварын төрөл	Үр дүн
1	Аргентин	1987	Хөрөнгө оруулалтын зориулалтаар ашигласан тайлагнаагүй байсан орлого	Мэдэгдэм үр дүн гараагүй
	Аргентин	1995	Татварын ерөнхий өршөөл	3.9 тэрбум доллар
2	Австрали	1980-аад онд 2 удаа	Татвараас зайлсхийсэн этгээдүүд	
3	Австри	1982	1979 оноос өмнө үүссэн татварын өр	Үр дүн муутай
	Австри	1993	Гадаадаас хөрөнгөө эргүүлэн татах зорилго бүхий тусгай хөтөлбөр	Татварын суурийг 58%-иар нэмэгдүүлсэн
4	Бельги	1984/1985	Хөрөнгө оруулалтад зарцуулсан хөрөнгө	Үр дүн муутай
5	Колумб	1987	Өмнө нь тайлагнаагүй хөрөнгө	ДНБ-ий 0.3%
6	Франц	1982	Татварын ерөнхий өршөөл, Гадаадаас хөрөнгөө эргүүлэн татах зорилго бүхий тусгай хөтөлбөр	Татварын орлогын 0.007%
	Франц	1986	Гадаадаас хөрөнгөө эргүүлэн татах зорилго бүхий 2 дахь тусгай хөтөлбөр	Татварын орлогын 0.008%
7	Энэтхэг	1981	Тайлагнаагүй орлогоор ЗГ бонд авахыг шаардсан,	
	Энэтхэг	1997	Татварын ерөнхий өршөөл	
8	Ирланд	1988	Татварын ерөнхий өршөөл	2.5 тэрбум доллар, Татварын орлогын 8.5%
	Ирланд	1993	Татварын ерөнхий өршөөл	700-750 сая доллар, Татварын орлогын 4.5%
9	Итали	1982	Татварын ерөнхий өршөөл	1988 оныхоос бага
	Итали	1984	Шинийг санаачлагчид болон өөртөө ажил олгогчид	100 сая доллар, татварын орлогын 15%
	Итали	2001/2002	Гадаадаас хөрөнгөө эргүүлэн татах зорилго бүхий тусгай хөтөлбөр	5 тэрбум доллар
10	Нидерланд	1934, 1940, 1945, 1955	Алданги, торгуулиас чөлөөлсөн	1.4 тэрбум евро, татварын орлогын 0.4%
11	Шинэ Зеланд	1988	Татварын ерөнхий өршөөл	Маш сайн
12	Португали	1981, 1982, 1986, 1988	Орлогын татварт хэсэгчлэн	18 сая доллар
13	ОХУ	1993	Өмнө нь татварын өртэй холбоотой хэрэгт холбогдоогүй хувь хүн, аж ахуйн нэгжүүд	Тооцоолсон орлогын 40%
	ОХУ	1996, 1997	Аж ахуйн нэгжүүд татварын ерөө хойшлуулж төлөх боломж олгосон	1996 сөрөг, 1997 эерэг боловч татварын орлогод маш бага нөлөө үзүүлсэн
14	Испани	1977	1976 оноос өмнө үүссэн татварын өрөнд ногдох торгууль	

Эх сурвалж: Torgler нар (2005)

хяналтын асуудалд илүү анхаарал хандуулан ажилласаар иржээ.

Манай улсад анх 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр “Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай”, 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдөр “Татварын өршөөлийн тухай” хуулиуд тус тус батлагдаж, хэрэгжиж эхэлжээ. Энэ хоёр хууль нь хоорондоо уялдаатай, тодорхой хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд татварын өршөөл үзүүлэх зорилготой байв. 2007 оны өршөөлөөр хувь хүний орлогын албан татварын тухай, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, онцгой албан татварын тухай, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр татвар төлөгчөөр бүртгүүлсэн буюу албан татвар ногдох бараа, ажил үйлчилгээ, үйл ажиллагааг мэдүүлсэн тохиолдолд тэдгээрийг хариуцлага болон албан татвараас нэг удаа чөлөөлсөн байна.

2008-2009 онд дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн ашигт малтмалын үнэ болон экспортын эрэлт огцом унасан явдал нь манай улсын эдийн засагт гаднаас хүндхэн цочрол болж, энэ нь эдийн засгийн бүтэц ба бодлогын орчинд оршиж байсан сул талуудыг улам даамжруулсан байна. Тухайлбал, хямралд өртсөнөөр төсвийн нөхцөл байдал ашигт малтмалын орлогоос улам бүр хараат болж, төсвийн ба урсгал дансны алдагдал огцом тэлж, 2008 оны эцсээр нэг томоохон банк дампуурч, мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн харьцаа алдагдсанаар эдийн засаг бүхэлдээ уналтад ороод байсан юм⁹. Үүнтэй холбоотойгоор 2008 онд татварын

өршөөл үзүүлж, зарим этгээдийг албан татвар, нийгмийн даатгалын өр, төлбөрийн тодорхой хувиас болон эрүү, захиргааны хариуцлага, эрүүгийн ялаас нэг удаа чөлөөлжээ. 2007-2008 оны өршөөлийн үр дүнд 4,621 татвар төлөгч 8,145 тайлан ирүүлж, 748 иргэн, хуулийн этгээд шинээр бүртгүүлсэн бөгөөд 4.5 их наяд төгрөгийн орлогод ногдох 431.6 тэрбум төгрөгийн татварыг өршөөлд хамруулжээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан нэмж мэдүүлсэн орлогын 49.1 хувь нь бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэгчид байна. Боловсруулах аж үйлдвэр 14.6%, барилга 13.9%, уул уурхайн салбар 7% татварын өршөөлийн хуульд хамгийн их хамрагдсан байна.

2015 онд манай улсын ДНБ 14,881.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 811.3 тэрбум төгрөг буюу 1 хувиар өссөн бөгөөд уг өсөлтөд ХАА-н салбар 9%-иар өссөн нь эерэг нөлөөлж, худалдааны салбарын 7%-ийн уналт, мөн бүтээгдэхүүний цэвэр татвар 15%-иар буурсан нь сөргөөр нөлөөлжээ¹⁰. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн тэнцэл нийт 1,163.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, өмнө нь өршөөлд хамрагдаагүй татвар төлөгчдөд боломж олгох үүднээс 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хуулийг баталж, хэрэгжүүлсэн байна. Энэхүү өршөөлөөр албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй, үл хөдлөх хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй, хөрөнгө орлогын мэдүүлэгт тусгаагүй, эсхүл хэмжээг нь бууруулсан,

⁹ Дэлхийн банк (2011)

¹⁰ Дэлхийн банк (2016)


нуусан, далд байгаа аж ахуйн нэгж, хөрөнгө, орлого болон орлогоос бусад албан татвар ногдох бараа, ажил, үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн, тайлагнасан, бүртгүүлсэн нөхцөлд нэг удаа албан татвар, хүү торгууль нөхөн ногдуулахгүй холбогдох хариуцлагаас чөлөөлжээ. Энэ удаагийн өршөөлийн дүнд 6.1 их наяд төгрөгийн хөрөнгө орлогыг ил болгосон нь ДНБ-ий 25%-тай тэнцүү байлаа.

Монгол Улсад хэрэгжсэн татварын өршөөлүүдийн үр дүнг татварын статистик мэдээнд үндэслэн дүгнэх оролдлого хийж үзвэл:

Татварын өршөөлийн үр дүнд богино хугацаанд татварын орлого огцом

нэмэгддэг. 2007-2008, 2015 онуудад хэрэгжсэн татварын өршөөлд хамрагдсан ААНОАТ, НӨАТ, ОАТ, ХХОАТ, ҮХЭХАТ гэсэн 5 төрлийн татвар болон татварын хүү торгуулийн орлогын 2002-2015 оны мэдээллийг дараах дүрслэлээс харж болно. 2007-2008 оны татварын өршөөлийн дараа татварын орлого огцом нэмэгдсэн ямар нэгэн үр дүн харагдахгүй, харин ААНОАТ 2009 онд өмнөх жилүүдийнхээс буурсан байгаа нь харагдаж байна. 2016 оны эцсийн татварын статистик мэдээ хараахан гараагүй байгаа бөгөөд 2016 оны эхний хагас жилийн татварын орлогын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом өөрчлөлт ажиглагдахгүй байна (Зураг 1).


Зураг 1. Татварын орлого (сая төгрөг)



Татварын өршөөлийн дүнд татварын бааз суурь нэмэгддэг. Татварын өршөөл хэрэгжүүлснээр татварын бааз суурь нэмэгдэж, урт хугацаанд татварын орлого нэмэгдэх нөлөөлөл үзүүлдэг хэмээн судлаачид үздэг. Манай улсад хэрэгжсэн татварын өршөөлийн үр дүнд татварын бааз суурь нэмэгдсэн эсэхийг тодруулах

зорилгоор татвар төлөгчөөр бүртгэгдсэн аж ахуйн нэгж байгууллагуудын тоог 2001-2016 оны эхний хагас жил хүртэлх байдлаар дараах дүрслэлд харууллаа. Уг дүрслэлээс харахад 2007-2008, 2015 оны өршөөлийн дараа татвар төлөгчдийн тоонд мэдэгдэм өөрчлөлт орсон үр дүн харагдахгүй байна (Зураг 2).

Зураг 2. Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо



Татварын өршөөлийн дараа татварын хуулийн хэрэгжилт сайжирдаг. Татварын өршөөлийн дараа татварын хуулийн хэрэгжилт сайжирсан бол татварын хүү, торгуулийн орлого буурсан байх ёстой боловч тийм үр дүн ажиглагдахгүй байна.

Өршөөлийн хуулийн хэрэгжилттэй холбоотой татвар төлөгчдийн байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлох зорилгоор 84 аж ахуйн нэгжээс асуулгын аргаар судалгаа авав. Уг судалгаанд оролцогчдын 75.6% нь худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг; 33.0% нь 0-500 сая; 31.0% нь 2 тэрбумаас дээш төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой; 48.0% нь ААНОАТ, ХХОАТ, НӨАТ-уудыг төсөвт төлдөг байна. Мөн 2015 оны татварын өршөөлийн хуулиар 47.6% нь 1-3 жилийн хугацааны хөрөнгө, орлогоо ил болгон

мэдүүлжээ. Тэдгээрийн 44.0% нь татварын дарамт их байдгаас шалтгаалан, 42.0% нь мэдлэг дутмаг, хугацаа хоцроосон, санамсаргүй алдааны улмаас хөрөнгө, орлогоо дутуу тайлагнасан гэж хариулжээ.

Татварын өршөөлийн хуульд хамрагдсан татвар төлөгчдийн 35.5%, хамрагдаагүй татвар төлөгчдийн 61.3% нь шударга бус, хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт нийцсэн өршөөл болсон гэж үзсэн байна. Нийт судалгаанд оролцогчдын 44.3% нь татвар төлөгчдөд хүлээлт үүссэний улмаас татвараа шударгаар тайлагнаж төлөх сонирхлыг бууруулна гэж үзсэн бол 62.0% нь татварын тэгш шударга зарчмын дагуу өршөөлд хамрагдаагүй татвар төлөгчдөд татварын хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Монгол Улсад хэрэгжүүлсэн татварын


Хүснэгт 2. Асуулгын судалгааны дүнгээс

Өршөөлийн хуульд хамрагдсан эсэх	Татварын өршөөлийн тухай хуулийн сөрөг тал			
	Шударга бус, хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхол нийцсэн	Татвар төлөгчид хүлээлт үүссэний улмаас татвараа шударгаар төлөх сонирхол буурна	Бусад	Мэдэхгүй
Тийм	35.3%	47.1%	11.8%	5.9%
Үгүй	61.3%	35.5%	3.2%	0.0%

өршөөлийн үр дүнгийн талаар татварын судлаач, зөвлөхүүдээс онлайн асуулга хэлбэрээр судалгаа авав. Судалгаанд нийт 28 мэргэжилтэн оролцсоны 50% нь 30-45 насны, 82% нь эмэгтэй байв. Судалгаанд оролцогчдын 44% нь 10

хүртэл жил, 40% нь 11-20 жил, 16% нь 21-ээс дээш жил татварын салбарт ажилласан туршлагатай байна. Татварын өршөөлийг хэрэгжүүлснээр гарсан үр дүнг судалгаанд оролцогчид дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

Зураг 3. Татварын өршөөлийн үр дүн



Дээрх дүрслэлээс харахад татварын өршөөлийн үр дүнг судалгаанд оролцогчдын 36% нь эерэг үр дүн гарсан гэж, 64% нь сөрөг үр дүн гарсан гэж үзсэн байна. Өршөөлийн хөтөлбөрүүдийн үр дүнгийн талаар асуулгад оролцогчид шударга бус байдлыг нуун далдлах зорилготой хууль байсан, шударгаар тайлагнаж татвараа төлж байсан аж ахуйн нэгжүүдээ дэмжээгүй гэсэн дүгнэлтүүдийг нэмж өгсөн байна.

Судалгаанд оролцогчдын 75% нь татварын өршөөлийн хуулиудад хамрагдаагүй, өөрөөр хэлбэл, татвараа шударгаар тайлагнан төлж ирсэн аж ахуйн нэгжүүдэд ирээдүйд тодорхой хугацаагаар татварын хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй хэмээн үзжээ. Мөн судалгаанд оролцогчдын 70.4% нь татварын өршөөлийг дахин давтан хэрэгжүүлэх шаардлагагүй гэж хариулсан байна.

Татварын өршөөлийн нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг 0-9 оноогоор


дүгнэхийг хүсэхэд нийт судалгаанд оролцсон мэргэжилтнүүдийн 67% нь 0-3 оноогоор дүгнэжээ (Зураг 4). Үүнээс үзэхэд судалгаанд оролцсон татварын мэргэжилтнүүд татварын өршөөлийн хуулиуд нь нийгэмд үзүүлэх эерэг нөлөө багатай, сөрөг үр дагавартай байсан ба дахин өршөөлийн хууль баталж хэрэгжүүлэх шаардлагагүй, харин уг хуулийн үр дүнд үүссэн тэгш бус байдлыг арилгах арга хэмжээ авч болно хэмээн үзэж байгаа юм байна.

Дүгнэлт

Татварын өршөөлийг татварын системийн гажуудал, нийгэм эдийн засагт нөлөө их байгаа, далд эдийн засгийн хүрээ өргөн, татварын зөрчил болон гэмт хэрэг нэмэгдсэн тохиолдлуудад хэрэгжүүлдэг.

Татварын өршөөлийг хэрэгжүүлсэн олон улсын туршлагаас харахад өршөөл үзүүлсний үр дүнд хяналт шалгалтын зардалгүйгээр татварын орлого, татварын

Зураг 4. Татварын өршөөлийн хуулийн нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөлд мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ



суурийг нэмэгдүүлж, хууль бусаар гадагш гарсан хөрөнгө орлогыг эргүүлэн татдаг байна. Татварын өршөөлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа татварын хяналт шалгалт, хүлээлгэх хариуцлагын хэмжээ, татварын албадын эрхийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг дагалдуулан хэрэгжүүлбэл татварын өршөөлийн үр дүн сайжирдаг. Мөн татварын өршөөлийн хөтөлбөр зарлах үедээ энэ талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах нь татварын өршөөлийн хэрэгжилтийн үр дүнд эерэг нөлөөллийг, дахин давтан хэрэгжүүлэх нь татварын өршөөлийн эерэг үр дүнг бууруулах сөрөг нөлөөллийг үзүүлдэг нь харагдаж байна.

Монгол Улсад 2007-2008, 2015 онуудад хэрэгжүүлсэн татварын өршөөлийн үр дүнгээс харахад татварын суурь болон орлогын хэмжээ төдийлөн өсөөгүй, өршөөлийн хуулийн дараа авч хэрэгжүүлэх ёстой татварын хяналт шалгалт, хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлээгүй байна. Түүнчлэн татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллага, татварын мэргэжилтнүүдээс авсан

асуулгын үр дүнгээс үзэхэд татварын өршөөлийн хөтөлбөрүүд нь нийгэмд үзүүлэх эерэг нөлөө багатай, сөрөг үр дагавартай байсан ба дахин өршөөлийн хууль баталж хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэх хандлага давамгайлж байна.

Үүнээс үзэхэд, Монгол Улсад хэрэгжүүлсэн татварын өршөөлийн хөтөлбөрүүд нь татварын орлогыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг ил болгох, татварын үндсэн зарчмуудыг хангах гэхээс илүү хэсэг бүлэг хүмүүсийн гэмт үйлдлийг хууль ёсны болгоход чиглэсэн үйл ажиллагаа байсан гэж дүгнэж болохоор байна. Цаашид татварын өршөөл хэрэгжүүлэх, өршөөлийн хууль хэрэгжүүлсний үр дүнд үүссэн сөрөг үр дагаврыг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

1. Татварын өршөөлд хамрагдсан болон хамрагдаагүй, өөрөөр хэлбэл татвараа үнэнээр нь төлж байсан аж ахуйн нэгжүүдийн хувьд тодорхой хугацааны турш ялгамжтай татварын бодлого хэрэгжүүлэх замаар татварын өршөөлөөр үүссэн тэгш бус байдлыг багасгах арга зам байж болох юм.

2. Ирээдүйд дахин татварын өршөөлийн хуулийг хэрэгжүүлэх бол уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор татварын албаны хяналт шалгалт, хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хамтад нь авч хэрэгжүүлбэл татварын өршөөлийн үр дүн нэмэгдэнэ.
- Цаашид татварын өршөөлийн далд эдийн засгийг бууруулахад нөлөөлсөн нөлөөллийг гүнзгийрүүлэн судлах, татварын өршөөлөөр үүссэн тэгш бус байдлыг арилгах арга замуудыг тодорхойлж хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Ашигласан материал:

1. Alm, J., Rath, D. M. (1998). Tax Policy Analysis: The Introduction of a Russian Tax Amnesty, *Working Paper 98-6*, International Studies Program, Georgia State University
2. Baer, K., Borgne, E. L. (2008). Tax Amnesties, Theory, Trends, And Some Alternatives
3. Feld, L. P., Schneider, F. (2010). Survey on the Shadow Economy and Undeclared Earnings in OECD Countries, *German Economic Review*, 11(2), 109–149
4. Kara, H. (2014). The Effects of Tax Amnesties on Tax Revenue and Shadow Economy in Turkey, Graduate School of Social Sciences of Middle East Technical University, Dissertation for the Degree of Master of Science
5. Luitel, H. S., Sobel, R. S. (2007). The Revenue Impact of Repeated Tax Amnesties, *Public Budgeting & Finance*, 27(3), 19-38
6. Marchese, C. (2014). Tax amnesties, *IEL Paper in Comparative Analysis of Institutions, Economics and Law*, No.17
7. Mouloud, M. (2015). The Tax Amnesty Program: as Tool to Adjust the Shadow Economy; the International Experiences, *Global Advanced Research Journal of Economics, Accounting and Finance*, 3(2), 17-25
8. Stella, P. (1989). An Economic Analysis of Tax Amnesties, *Working Paper 42*, International Monetary Fund, Washington, D.C.
9. Summers, L. H. (1987). Tax Policy and the Economy, The MIT Press, 55-86
10. Torgler, B., Schaltegger, C. A. (2005). Tax Amnesties and Political Participation, *Public Finance Review*, 33(3), 403-31
11. Дэлхийн банк (2011). Монголын эдийн засгийн тойм 2008-2010 он
12. Дэлхийн банк (2016). Монголын эдийн засгийн тойм 2015 он
13. www.mta.mn
14. www.mongolbank.mn
15. www.1212.mn
16. www.eastasiaforum.org

